

**НАМЫН ХӨГЖЛИЙН ХАНДЛАГА, МОНГОЛЫН НАМУУДАД
ТУЛГАРЧ БУЙ СОРИЛТ**

С.Мөнхбат

Докторант

(МУИС, Улс төр судлалын тэнхмийн багш)

Хураангуй. Орчин үеийн улс төрийн намын шинэчлэл, хөгжлийн асуудлыг судалж тулгаран буй сорилт, бэрхшээлүүдийг Монголын улс төрийн намуудын хөгжил, төлөвшилтийн жишээн дээр тодруулан гаргахыг эрмэлзэв. Ингэхдээ намын хөгжлийн ерөнхий чиг хандлага, үндсэн хэв маягууд (элит нам, олон түмний нам, өргөн хүрээний нам, картель нам)-ын ялгаа, онцлогуудыг тодруулах замаар Монголын намуудтай харьцуулан авч үзэхийг хичээв.

Түлхүүр үг. Элит нам, боловсон хүчний нам, олон түмний нам, картель нам, намын бүтэц зохион байгуулалт, үзэл суртал, дотоод ардчилал

Германы социологич М.Вебер улс төрийн нам нь үүсэж хөгжих явцдаа язгууртны бүлэглэлүүд, улс төрийн дугуйлан-клуб болон олон түмний нам гэсэн гурван шатыг дамжиж ирсэн тухай бичжээ. Улс төрийн сэтгэлгээний түүхэнд Английн лейборист (Виги) нам, Консерватив (Тори) хоёр нам л дээрх гурван шатыг туулан хөгжсөн байна. Орчин үеийн намуудын түүхээс үзэхүл олонх нь шууд олон түмний намын хэлбэрээр төлөвшин бий болжээ. Францын судлаач М.Дюверже нам үүсэн бий болох шалтгааныг парламентын ардчилалтай, олон намын тогтолцоог плюрализмтай, парламентат ёсны төлөвшлийг бүх нийтийн сонгуулийн эрхтэй амин шүтэлцээтэй авч судалсан нь намын нийгэмд гүйцэтгэх үүрэг хийгээд ардчиллын бэхжилт намаас хэрхэн хамаардаг болохыг тодруулан гаргахад арга зүйн ач холбогдолтой болсон юм.

Өнгөрсөн XX зуун улс төрийн намуудын хөгжлийн алдаа оноог дэнсэлсэн зуун болж дэлхийн ардчилсан орнууд дахь намуудын үйл ажиллагаа, үзэл баримтлал, үнэт зүйлсд чухал өөрчлөлтүүд гарсан нь ардчиллын хэмжүүр улс төрийн намууд юм гэсэн үзэл санааг түгэн дэлгэрүүлэхэд хүргэсэн нь оргүй зүйл биш юм. Үнэндээ ч нам нь ардчиллыг хэрэгжүүлдэг, түгээдэг, тээж явдаг, хөгжүүлдэг улс төрийн системийн чухал институт юм. Энэ нь намын нийгэмд гүйцэтгэж ирсэн, гүйцэтгэж буй үүргүүдээр тодорхойлогдож байдаг юм. Нам өөрийн зохион байгуулалтын ажил, үзэл суртал, байр суурь, нэр дэвшигчдийг таниулж дэмжүүлэх үйл ажиллагаа, зохион байгуулалтын ажлынхаа явцад улс төрийн соёлыг төлөвшүүлэн улс төрийн нийгэмшлийн чиг үүргийг биелүүлж байдаг. Нам төрд ажиллах албан тушаалтнуудыг бэлтгэж, сонгон шалгаруулах гол механизм байж улс төрийн шүүлтүүрийн үүрэг гүйцэтгэдэг. Энэ мэтчилэнгийн үүргүүд нь улс төрийн намын өөрийн бодлого, нэр дэвшигчдээ дэмжүүлэхэд олон түмнийг дайчлах гол зорилтыг хангахад чиглэж цаашид нийгмийн ашиг сонирхлыг нэгтгэх үйл явцтай холбогддог.


Орчин үеийн намуудын функциональ тал ийм боловч интституциональ талаасаа бүтэц, зохион байгуулалт, дотоод ардчиллын хувьд хөгжлийн хоёр үндсэн хэв маяг тогтон төлөвших хандлага ажиглагдаж байна. Эхнийх нь уламжлалт хатуу бүтэцтэй, татвар төлдөг гишүүнчлэлтэй, үзэл суртлын тогтсон үнэт зүйлстэй намууд (Европын ихэнх социалист, коммунист консерватив намууд), хоёр дахь нь Америкийн намын хэв маягийг тусгасан төвлөрсөн бус, сулхан зохион байгуулалт бүхий, хатуу гишүүнчлэлгүй намын хэв маяг юм.

Иймд орчин үеийн улс төрийн намын хөгжил, чиг хандлагыг судлан үзэхэд дараах дөрвөн шинжид анхаарал хандуулах нь чухал ач холбогдолтой болж байна.

хамарсан байхыг шаардаж, хэвлэл мэдээллийн нээлттэй байдал нь намын удирдагчдыг тухайлсан бүлгүүдийн биш, нийт сонгогчдод зэрэг хандах боломж олгосон зэргээс эх үндэстэй байв. "Эдгээр нам нь нийгмийн нийт бүлгийн ашиг сонирхлыг төлөөлөх бус харин үндэсний ашиг сонирхлыг удирдлага болгох ёстой. Тухайн намуудад олон тооны идэвхтэй гишүүдээс илүү телевизээр дамжуулан сонгогчидтой холбоо тогтоож байдаг лидерүүд давамгайлж байдаг. Ийм маягийн намын хувьд сонгогчдын дэмжлэг чухал ч тэдгээрийн зорилго нь төлөөлөхдөө бус, харин удирдахдаа оршдог"³⁹ аж. Испани, Их Британид хэд хэдэн радикал социалист намууд лидер тэргүүлсэн социал демократ намууд болон өөрчлөгдсөн нь олон түмний нам өргөн хүрээний намд шилжсний жишээ юм. Мөн Германы Христосын ардчилсан нам католик шашныг хамгаалдаг байгууллагаас баруун төвийн өргөн олны нам болж өргөжсөн жишээ байна.

Орчин үеийн намын хөгжлийн чиг хандлага нь намыг төр, иргэний нийгмийн хооронд зуучлагч, брокер болгон хувиргах, намуудын хоорондын харилцааг төлөвшүүлэхэд ихээхэн чиглэгдэх болсон нь улс төрчдийн мэргэшсэн бүлгүүдийн дунд төрийн албан тушаалуудыг хуваарилах механизм болсон "картель нам"⁴⁰-ууд үүсэх нөхцөл болжээ. Картель нам нь төрийн зүгээс намуудыг хүчтэй дэмжсэн газарт гарч ирсэн бөгөөд ийм намууд хоорондоо хорших, хамтран ажиллах уламжлал дээр суурилан бодлого, үйл ажиллагаагаа явуулдагаараа бусад намын хэв маягаас ялгаатай юм. Тухайлбал "улс төрийн намууд төрийн албан тушаалын төлөө өөр хоорондоо өрсөлдөх нь урьдын адил хэвээр боловч тэдгээр нь үүнийг зохион байгуулалтын хувьд хамтаараа тэсч үлдэх, хэн хэнийхээ ашиг сонирхлыг өрсөлдөгчидтэйгээ хуваалцах, зарим тохиодолд бүр өрсөлдөх, тэмцэлдэх хязгаарлагдмал тэмүүллийг өрсөлдөхгүй байх позитив тэмүүллээр хэрэг дээр нь солихыг хүлээн зөвшөөрөх замаар хийдэг"⁴¹ хэмээн судлаач Р.Катц, П.Майр нар тэмдэглэсэн байна. Ардчиллын эрчимжилтийн эрин үед намуудын мөрийн хөтөлбөрийн адилсал нь төрийн бодлогын хариуцлагыг бүх намууд үүрэхэд хүргэж, харин тодорхой намын хариуцлагыг нимгэлж өгч байдаг нь картель намуудын нэг онцлог гэж болно.

Бүдүүвч.3 Намууд төр,иргэний нийгмийн хооронд зуучлагч байгууллага болох нь



Эх сурвалж: Katz.R.S.; Mair P. // Party Politics.Vol.1.No.1. 1995

Орчин үеийн намын хөгжлийн дээрх хэв маягууд, тэдгээрийн шилжилтүүд нь ардчиллын ямар загвар байгаагаас хамааран харилцан адилгүй байдаг болохыг судлаачид тогтоожээ.

³⁹ "Áîâ-èí. Õàðüóóóëñàí òëñ ò°ð.ÓÁ.,2006.óóóääñ.202

⁴⁰ Katz.R.S.; Mair P. Changing models of party organization and party democracy: The emergence of the cartel party// Party Politics.Vol.1.No.1. January 1995. P. 5-28

Katz.R.S.; Mair P. Cadre, Cath-All ïr Cartel?// Party Politics.Vol.2.No.4. January 1995. P. 525-534

⁴¹ "Áîâ-èí. Õàðüóóóëñàí òëñ ò°ð.ÓÁ.,2006.óóóääñ.203

Намын зохион байгуулалтын загварууд, онцлог шинжүүд

ЭЛИТ НАМ	ОЛОН ТҮМНИЙ НАМ	ӨРГӨН ХҮРЭЭНИЙ НАМ	КАРТЕЛЬ НАМ	
<i>Гарч ирсэн үүсэл</i>	XIX зуун Парламент дотор	1880-1960 Парламентын гадна хөгжсөн	1945 оноос хойш Элит, масс намаас	1970- Намуудын хослол
<i>Гол шаардлага</i>	Лидерүүдийн уламжлалт статус	Нийгмийн бүлгийн төлөөлөл	Удирдах ур ухаан	Мэргэшсэн улс төр
<i>Гишүүнчлэл</i>	Цөөн элит	Батлах бүхий олон тооны гишүүд	Лидерүүд зонхилдог болсон	Олонд хүлээн зөвшөөрөгдсөн гишүүд
<i>Орлогын эх үүсвэр</i>	Хувийн холбоо	Гишүүдийн татвар, хандив	Төрийн санхүүжилт, бусад олон эх үүсвэр	Төрийн санхүүжилт
<i>Намын иргэний нийгэм, төрийн хоорондох байр</i>	Төр, иргэний нийгмийн хил зааг тодорхой бус байдаг	Нам иргэний нийгэмд багтдаг ба иргэний нийгмийн шинэ сегментүүдийн төлөөлөл байдаг	Нам нь иргэний нийгэм төр хоёрын хооронд өрсөлдөгч брокерүүд байдаг	Нам төрийн нэг хэсэг болсон байдаг.
<i>Төлөөллийн хэлбэр</i>	Итгэмжлэгдсэн хүн	Төлөөлөгч	Entrepreneur	Төрийн агент
<i>Жишээ</i>	XIX зууны либерал намууд Посткоммунист намууд	Социалист намууд	Европын орчин үеийн Христосын болон Социаль демократ намууд	Английн Лейборист нам, Шведийн социал-демократ нам гэх мэт

Орчин үеийн Монголын намуудын хөгжил, тулгарч буй сорилт, чиг хандлага:

1990 оны ардчилсан хувьсгалын үр дүнд Монгол улс нийгмийн шинэ тогтолцоонд шилжсэнээр улс төрийн хүрээний бүх эрхүүд тэр дундаа сайн дураараа эвлэлдэн нэгдэх, улс төрийн нам болон бусад институциудыг байгуулах, сонгох, сонгогдох эрхийн зарчмуудыг Үндсэн хуулиар баталгаажуулсан билээ. Олон намын системийн эрх зүйн орчин ч бүрдэв. Шинээр гарч ирсэн намууд мэргэжлийн, тухайн үед байсан болон шинээр төлжин буй нийгмийн бүлгийн шинжээр байгуулагдаж байв. Тухайлбал. Хөрөнгөтний нам, Тариачны нам, Ажилчны нам, Малчны нам гэх мэт. Нийгмийн социаль бүтцийн шинжээр зохион байгуулагдсан намууд өмнөх нийгмийн тогтолцоонд хэвшин тогтсон намын зарим шинжүүдийг шууд хуулбарлан хэрэглэж эхэлсэн юм. Судлаач Д.Ганхуяг “Шинээр төрөн гарч буй намуудыг МАХН-аас гаралтай, түүний боловсон хүчнээс үүдэлтэй байсан нь гарцаагүй бөгөөд жам ёсны үзэгдэл байсан....Ийм болохоор шинэ ардчилсан гэх намууд МАХН-ыг шүүмжилж, өөр үзэл суртал, үзэл санааг тунхаглахын хамтад зохион байгуулалт, удирдлагын хувьд түүнийг загвар болгон байгуулагдсан юм”⁴² хэмээн шинэ намуудын үүслийн үйл явцыг дүгнэжээ.

Монгол улс ардчилсан хөгжлийн замаар замнаад даруй арван найман жил болж байна. Монголын ардчилалд дээрх хугацаанд алдаа оноо аль аль нь байсныг үгүйсгэх аргагүй бөгөөд энэ байдал ч улс төрийн намуудыг тойрч гараагүй юм. Энэ байдал намуудын төлөвшилтийн үйл явцад тод илэрлээ олсон юм. Ингээд эл хугацаан дахь намуудын төлөвшлийн үйл явцыг үндсэн хоёр хэсэгт хуваан авч үзье. Үүнд:

1. (1990-2004 он): Нийгэм нэг үзэл суртал, нэг намын хатуу хяналтаас ангижирч, улс төрийн плюрализм хөгжин олон намууд шил шилээ даран гарч ирэх хөрс бүрэлдсэн үе байв. Европын намуудын загвар болох элитар болон олон түмний намын хэлбэрээр бий болсон намууд (либераль, консерватив, социалист, социал-демократ, экологи, шашин, иргэний чиглэлийн) ихээр төрж байсан цаг үе юм. Гэвч

⁴² ᠠ.ᠠᠠᠢᠳᠣᠭᠠ. ᠣᠡᠨ ᠔᠐᠔ᠡᠢ ᠶ᠋ᠠᠢ, ᠔ᠡᠨ ᠔᠐᠔ᠡᠢ ᠣᠳᠨᠦᠡᠠᠳᠦ, ᠨᠢᠶ᠋ᠠᠳᠦᠡᠡ ᠵᠡᠡ ᠶ᠋ᠠᠳᠦ. ᠨᠢᠶ᠋ᠡᠢᠶ᠋ᠡᠢᠶ᠋ᠡ
ᠨᠢᠶ᠋ᠠᠳᠦᠵᠡ.1.6.ᠶ᠋ᠣᠡᠨ.ᠣᠠ.2005.᠔᠐᠔ᠠᠠᠨ.61

намын хөгжил, төлөвшилтийн явцад европын намуудын уламжлалт загварыг хуулбарлан авсан явдал Монголчуудын сэтгэлгээ, нийгэм ахуйн орчинд төдийлөн идээшиж өгөхгүй байдал анхнаасаа мэдрэгдэж эхэлсэн нь намын төлөвшилтийн хямралын эх үндэс байв. Энэ нь доорх шалтгаануудтай холбоотой гэж судлаачид үзэж байна.

1. Монголчууд түүхэндээ парламентын ардчиллыг төлөвшүүлж, бүх нийтийн сонгуулийн эрхийг хууль эрх зүйн хүрээнд бэхжүүлж нийгмийн амьдралд хэвшүүлсэн уламжлал байгаагүй учраас олон намын систем, хэв маяг бий болох хөрс суурь байгаагүй юм. Нөгөө талаас манайд нэг хүний дангаар захирах дорно дахины засаглалын түгээмэл хэлбэр болох диспотизм хүчтэй ноёрхож ирсэн уламжлал.
2. Өнөөгийн Монгол улсын нийгмийн бүтцийн гол бүрэлдэхүүн хэсэг нь (мэргэжлийн ажилчид, сэхээтэн, албан хаагчид, номинклатур анги) социализмын хөгжлийн үед бүрэлдэн бий болсон гэж үздэг. Социалист Монголд хувийн өмч байгаагүй. Иймээс улс төрийн хүсэл эрмэлзлийг бүрдүүлэн өрсөлдөх нийгмийн тодорхой бүлгүүд бүрэлдэн төлөвшиж чадаагүй билээ. Нийгмийг бүхэлд нь хамарсан шашингүйжүүлэл нь бүхэлдээ нэг дан хэвтэй (хомоген) нийгэм төлөвшихөд түлхэц болж өгсөн зэргийг онцолж байна.

2.(2004-өнөөг хүртэл) Энэ үеийг намуудын хямралын үе хэмээн үзэж болох бөгөөд намуудын үүсэл, хөгжлийн хоёр дахь үе гэж дүгнэж байна. Төрийн ардчилсан институтуудыг бэхжүүлэх, парламентат ёсыг төлөвшүүлэх, нийгэмд олон ургальч ардчиллыг хөгжүүлэхэд шинээр бий болсон намуудын гүйцэтгэсэн үүргийг үгүйсгэж эс болох авч орчин үеийн нийгмийн хөгжлийн шаардлага, дэлхийн хөгжлийн нийтлэг чиг хандлагад тохирсон намын хэв маяг, бүтэц, үйл ажиллагаа өнөө хэр үгүйлэгдсээр байна. Нийгэм, эдийн засгийн хямрал, улс төрд үүрэлсэн олигархи бүлэглэлүүд, тэдний ашиг сонирхлын зөрчил, авилга, хээл хахууль нийгэмд нийтлэг үзэгдэл болсон зэрэг сөрөг үзэгдлүүд намд итгэх иргэдийн итгэлийг улам бүр бууруулсаар байна.



Эх сурвалж: Werner Prohl, L.Sumati. Voter's Voices.2008.p. 231

Намын удирдлага, элит хэсэг эрх мэдэл, ашиг сонирхлоо дагаж жирийн гишүүд, олон түмнээс тасрах хандлага илт мэдрэгдэж байна. Улс төрд үүсдэг энэ

Монголын намуудад улс орныг ирээдүйд хөтлөх үзэл концепци, стратеги өнөө хэр байхгүй байна. Намуудын нийгмийг хөгжүүлэх үзэл баримтлал, стратеги нь өөр хоорондоо агуулга, хэлбэр, хэрэгжүүлэх арга хэрэгслийн хувьд ялгаатай байх нь иргэдэд бодлого сонгох альтернатив боломж олгодоогоороо дэвшилттэй байдаг. Үзэл баримтлалд суурилсан намуудын бодлого нийгмийн эрэлт, хэрэгцээнээс үүдэлтэй нийт нийгмийн ашиг сонирхолд харшлахгүй байхаар боловсрогдсон байх ёстой.

Үзэл баримтлалын үнэт зүйлс бүрэлдээгүй байгаагаас либерал намууд радикал бодлого тунхаглаж, социалист, социал-демократ намууд либераль бодлого ярьж, зүүний нам барууны намтай нэгдэж байна. Монголын намууд үзэл баримтлал, концепци тойрч нэгдсэн улс төрийн хүч гэхээс эд мөнгө, эрх мэдэл, ашиг сонирхол тойрч нэгдсэн бүлэглэл болон хувирчээ. Нам, төрд ажиллах боловсон хүчнийг шилж сонгодог шүүлтүүр байхаа нэгэнт больж эсрэгээр намаар дамжин төрд шураглан нийтийн бүтээсэн баялагаас хувь хүртэгсэд, хүртэхийг горилогчдын үүр, уурхай болоход хүргэж байна. Иймд Монголын намууд үзэл баримтлалдаа чиглэлд дараах шинэчлэлийг хийх явдал чухал байна. Үүнд:

- Баруун чиглэлийн намууд либерал бодлогыг үйл ажиллагааныхаа удирдлага болгох, ягштал баримталдаг байх
- Зүүний намууд нийгмийн халамж, хамгааллын бодлого, социал баримжаат нийгмийн ардчиллыг бэхжүүлэхэд чиглэсэн бодлого, алхамуудыг тодорхойлон гаргах
- Намууд нэгэнт олон түмний намын шинжээр байгуулагдаж ажиллаж буй учир нийгмийн аль хэсэг, давхаргад суурилж, тэдний дэмжлэгийг авч буй байдалдаа нийцүүлж үзэл баримтлал, бодлогоо боловсруулах
- Дэлхий нийтийн улс төрийн үнэт зүйлсийг үзэл баримтлал, бодлогодоо зөв тусгах, ингэхдээ аль болох прагматик шинжийг илүү баримтлах
- Сонгуулиас сонгуулийн хооронд сонгогчдоос оноо цуглуулах байдлаар, асуудалд “гал унтраах” арга барилаар хандах бус алсыг харсан, ирээдүйд чиглэсэн бодлогыг тогтсон үзэл баримтлалын суурин дээр дэвшүүлж ажиллах
- Үзэл баримтлалаа нийгмийн амьдралын бодит ахуйд суурилуулан, нийгмээс угтай бодлогыг хэрэгжүүлэх замаар нийгэмд таниулан сурталчилж, байнга боловсронгуй болгож байх. Өөрөөр хэлбэл намууд үзэл баримтлалаа бодитой амилуулах шаардлагатай гэсэн үг юм.

АНУ-ын судлаач сонирхлын бүлгийн онолыг үндэслэгч А.Бентли “Нийгмийг танин мэдэх үйл явц нийгэмд байгаа сонирхлуудыг танин мэдэхээс эхэлдэг”⁴⁵ гэж дүгнэсэн. Мөн ардчиллын онолын нэрт төлөөлөгч Р.Даль “Ардчиллын эцсийн үр дүн нь ард түмний үнэлэлт, ард түмний дэмжлэгээр дүгнэгддэг” гэж бичсэнийг санахад бас илүүдэх юун.

2-рт: Бүтэц зохион байгуулалтын шинэчлэл: Улс төрийн ухаанд намуудыг бүтэц зохион байгуулалтаар нь нээлттэй ба хаалттай (хатуу) гэж хоёр ангилдаг. Монголын бүх намууд зохион байгуулалтын хатуу бүтэцтэй. Удирдлагын босоо тогтолцоотой, үүнийгээ дагаад бодлого шийдвэр гаргах үйл явцад доод шатны нэгжүүд, гишүүд дэмжигчдийн оролцоо бага зэрэг намын дүрэм бусад хэм хэмээний хүрээнд хязгаарлалттай байгаа шинжүүд нь хатуу бүтэцтэй намуудын ангилалд хамруулах үндэслэл болж байна. Монголын намуудад биелэлээ олсон зохион байгуулалтын хатуу бүтэц ХХ зууны 60-аад онд өрнөдийн орнуудын намуудын зохион байгуулалтын үндсэн хэв маяг болж байсан хэдий ч өдгөө нээлттэй, ардчилсан хэлбэр, хэв маягуудаар баяжигдан хувьсжээ. Иймд монголын намууд бүтэц, зохион байгуулалтын хоцрогдмол энэ хэв маягаас аль болох татгалзах шаардлагатай байна.

⁴⁵ А.О. Øàíàçàðíàà. Ñíàðàíàíàü áóðæóàçàü ïèèèè-àñèàü íàòèà: ìðíàèàíü àíñóààðñòàà è ààíèèðàèèè. Ì., 1982.ò. 65

Монголын намуудыг нийгмийн хэрэгцээнд тохирсон, ашиг сонирхлын агрегацийг чадварлаг гүйцэлдүүлж чадахуйц бүтэц, үйл ажиллагааны хэлбэрт оруулах нийгмийн хэрэгцээ, шаардлага байна.

Үүнийг хийхийн тулд юуны өмнө намуудын анхан шатны байгууллагуудад дүрмээр үлэмжхэн хэмжээний эрх мэдэл олгож, намын бодлого, шийдвэр гаргах үйл явцад гишүүд, дэмжигчдийн оролцоог өндөржүүлэх явдал чухал байгаа юм.

- Намын удирдах дээд байгууллагын хүрээн дэхь шинэчлэл / Их хурал, түүний үүрэг, хуралдуулах үндэслэл, хурлаар шийдвэрлэх асуудлууд, эрх үүрэг, хурлын төлөөлөл, төлөөлөгчдийн эрх, үүрэг, ил тод байдал/
- Намын дунд шатны байгууллагын хүрээн дэхь шинэчлэл /үүрэг, функц, түүний төлөөллийн механизм, ил тод байдал, шийдвэр гаргах үйл явцдаа гишүүдийн санал, хүсэлтийг харгалзан үзэх боломж /
- Намын анхан шатны нэгжүүдэд хийх шинэчлэл/ анхан шатны нэгжүүдийн эрх үүргийг дээшлүүлэх, намын шийдвэрийг анхан шатны нэгжүүдийн шийдвэр, хүсэлтэд үндэслэн гаргадаг тогтолцооны механизмыг төлөвшүүлэх
- Намын удирдлага түүний бүтэц зохион байгуулалтын шинэчлэл, удирдлагыг төвлөрлийг сааруулахад хийх алхамууд /намын дарга, ерөнхий нарийн бичгийн дарга, нарийн бичгийн дарга нарын ажлын аппаратын шинэчлэл, бүтцийн чадварлаг, нээлттэй байдлыг хангах арга замууд /
- Намын парламент дахь бүлгийн шинэчлэл, хууль тогтоох байгууллага дахь намын бүлгийн ажил, парламентын гишүүд намын хоорондын харилцаа, хариуцлагын механизмын хууль эрх зүйн зохицуулалтыг сайжруулах

Бүтэц зохион байгуулалтын дээрх шинэчлэлүүд Үндсэн хууль, улс төрийн намын тухай хууль, сонгуулийн хууль зэрэг бусад олон эрх зүйн актуудтай уялдаатай байдаг учраас зарим нэг бэрхшээл гарахыг үгүйсгэх аргагүй ч цаашид тогтолцооны хүрээнд боловсронгуй болгох шаардлага байгаа юм.

3-рт намын дотоод ардчиллыг бэхжүүлэхэд хийх шинэчлэл: Нам ардчиллыг тээж явдаг институци юм. Иймд нам дотооддоо ардчиллыг дархлаажуулсан байх нь чухал. Намын дотоод ардчиллыг бэхжүүлэхэд чиглэж хийх алхмууд:

- Намын бодлого шийдвэрийг гаргахад гишүүдийн оролцоог нээлттэй байлгах
- Намын анхан болон дунд шатны нэгж, байгууллагуудын эрх мэдлийг өргөтгөх, үйл ажиллагааг идэвхжүүлэх
- Намын бодлого, шийдвэр дээрээс бус анхан болон дунд шатны нэгж, байгууллагуудын оролцоотойгоор гардаг тогтолцоонд шилжих
- Нам доторх эрүүл, саруул плюрализмыг хүлээн зөвшөөрөх, бодлогын олон янзын альтернативуудыг өрсөлдүүлдэг, дэвшилттэйг намын стратеги, бодлого болгон ашигладаг байх
- Боловсон хүчнийг шилж сонгох үйл ажиллагаа шударга, нээлттэй, өрсөлдөөн дээр үндэслэгдсэн байх,
- Улс төрийн ёс суртахууны өндөр эрхэмлэлийн шалгуурыг бий болгосон байх
- Намын удирдлагын үйл ажиллагааг захиран тушаах удирдлагын хэлбэрээс заавар, зөвлөгөөг сонсдог, үйл ажиллагаагааныхаа төлөө хариуцлага хүлээдэг, тайлагнадаг зэрэг орчин үеийн ардчилсан удирдлагын арга барилд шилжүүлэх явдал юм.

Дээрх алхмуудын хүрээнд авч үзэхэд монголын намуудад дотоод ардчилал дутмаг байгааг илхэн харж болно. Иймд намууд цаашдын үйл ажиллагаандаа, нам нь төрийн түвшинд улсыг удирддаг институци гэдгээ гүнээ ухамсарлаж, төр, нийгмийг холбодог, иргэдэд үйлчилдэг, тэдний дуу хоолой, ашиг сонирхлыг хангадаг байх гэсэн үндсэн үүргээ сайн биелүүлж ажиллах явдал юу юунаас чухал байна.

Ашигласан, ишлэл авсан ном, материал

1. М.Дюверже. Политический партии. М., 2000
2. Sartori. Political parties: parties system. USA., 19
3. Robert Michels. Political parties: a sociological study of the oligarchical tendencies of modern democracy. USA., 1958
4. Angelo Panebianco. Political parties: organization and power. Cambridge., 1978
5. Micheal. J. Sodaro. Comparative politics. A Global Introduction. USA., 2001
6. Г.Х.Шахназарова. Современная буржуазная политическая наука: проблемы государства и демократии. М., 1982
7. Б.Болд-Эрдэнэ. Монголын улс төрийн нам, намын систем. УБ., 2000 он
8. Ж.Заанхүү. 1990 оны ардчилсан хөдөлгөөний түүхэнд холбогдох баримт бичгүүд. УБ., 2004 он
9. Г.Алмонд, Дж.Пауэлл нар. Харьцуулсан улс төр. Орч. Ё. Довчин. 2005 он
10. Ё. Довчин. Харьцуулсан улс төр судлал. УБ., 2006 он
11. Зүүн Азийн барометр. Ардчиллын хөгжлийн харьцуулсан судалгаа. УТБА., 2005 он
12. А. Юндэндорж. Нийгэм иргэнлэг, ардчилсан хэв шинжийг олоход төрийн институтын гүйцэтгэх үүрэг. УБ., 2001 он
13. Политологи сэтгүүл. 12. МУИС. УБ., 2005 он
14. Альтернатив сэтгүүл. 11. Альтернатив төв. УБ., 2003 он
15. Монгол Улсын Үндсэн хууль. УБ., 1992 он
16. Улс төрийн намуудын тухай Монгол улсын хууль. УБ., 2005 он
17. МАХН-ын XXI үеийн их хурал: илтгэл, баримт бичгүүд. УБ., 2005 он
18. Richard S. Katz and Peter Mair. Changing models of party organization and party democracy. The Emergence of the Cartel party. // Party politics. Vol. 1. No. 1. 1995
19. Richard S. Katz and Peter Mair. Cadre, Catch-All or Cartel? // Party Politics. Vol. 2. No. 4. January 1995
20. Pippa Norris. May's law of curvilinear disparty revisited. // Party politics. Vol. 1. 1995
21. Mark Blyth and Richard S. Katz. From Catch-all Politics to Cartelisation: The political economy of the Cartel party. // West European Politics. Vol. 28. 2005
22. Werner Prohl, L. Sumati. Voter's Voices. 2008